210601	Багаж, техник, хэрэгсэл	-	252,851,230.31
210602	Тавилга	-	4,167,000.00
210604	Урсгал засвар	-	76,001,829.50
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>448,446,354.25</b>
210701	Гадаад албан томилолт	-	91,511,504.25
210702	Дотоод албан томилолт	-	356,934,850.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>315,361,339.43</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	299,609,827.23
210803	Даатгалын үйлчилгээ	-	7,964,089.20
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	2,002,271.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,753,452.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	31,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>7,423,590.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,999,990.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,423,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>215,312,122.69</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	<b>180,195,122.69</b>
<b>21311</b>	<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>	-	<b>180,195,122.69</b>
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	180,195,122.69
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	8,887,304.69
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	171,307,818.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>35,117,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	25,817,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	9,300,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>410,700,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	410,700,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	410,700,000.00
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-	<b>(387,799,562.13)</b>
<b>5</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>387,799,562.13</b>
<b>6</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	-	<b>387,799,562.13</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Одон орон геофизикийн хүрээлэнгийн эрхэм зорилго нь “Хүн төрөлхтний соёл иргэншил, дэлхийн шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Монголын Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжсэн үндэсний шинжлэх ухаан, технологийн салбар, түүний дотор одон орон, геофизик, сансар судлалын ухааны цогц хөгжлийг хангах”-д оршино гэж тодорхойлсон байна.

Одон орон, геофизикийн хүрээлэн үйл ажиллагааны чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Астрометрийн салбарын зорилт: Тэнгэрийн эрхсийн ажиглалт, судалгаанд шинэ арга зүйг нэвтрүүлж судалгааны шинэлэг үр дүнг гарган авч олон улсын мэдээллийн санд бүртгүүлэх;
- Астрофизикийн салбарын зорилт: Нарны физик, од галактикийн судалгааг орчин үеийн багаж төхөөрөмж онолын загваруудад түшиглэн шинэ түвшинд хүргэх;
- Астропаркийн салбарын зорилт: Монголын нийгэмд одон орон сансар судлалын шинжлэх ухааныг таниулан сурталчилж, шинжлэх ухаанч хүмүүжил олгох, мэргэжлийн сургалт хурал, семинар зохион байгуулж, шинжлэх ухааны товхимол хэвлэн гаргах;
- Соронзон судлалын салбарын зорилт: Дэлхийн үндсэн болон хувьсах соронзон орны судалгааг өргөжүүлж мэдээлэл боловсруулалтад шинэ арга, аргачлалыг нэвтрүүлэх, судалгааны дүнг олон улсын өндөр зэрэглэлийн сэтгүүлүүдэд хэвлүүлэх;
- Газар хөдлөл судлалын салбарын зорилт: Станцуудын техникийн хүчин чадлыг нэмэгдүүлж Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд газар хөдлөлтийг бүртгэх чадлыг магнитуд 1.5-д хүргэх;
- Орон нутаг дахь салбаруудын зорилт: Орон нутаг дахь салбаруудыг бүсчлэн хөгжүүлж, геофизикийн судалгааны тулгуур төвүүд болгох, бүс нутгийн хэмжээнд геофизикийн судалгаа, ялангуяа газар хөдлөл судлалын чиглэлээр судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хүрээлэн үйл ажиллагаандаа Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль эрхийн актыг мөрдөн ажилладаг.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Монгол улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25 өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоол 6

Тус хүрээлэнгийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд тайлант хугацаанд дээд шатны төсвийн захирагчаас хяналт, шалгалт хийгдээгүй байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хүрээлэн нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байна.

Тус хүрээлэн нь 2024 онд Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын багцад шилжиж ирсэн боловч салбарын онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,233,933.7 мянган төгрөг буюу 56.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	399,361.0	11,561.4	(387,799.6)
Авлага	11,956.6	171,307.8	159,351.2
Бараа материал	148,471.3	21,201.4	(127,269.9)
Үндсэн хөрөнгө	13,911,368.9	22,501,020.9	8,589,652.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>14,471,157.8</b>	<b>22,705,091.5</b>	<b>8,233,933.7</b>
Засгийн газрын хувь оролцоо	14,471,157.8	22,705,091.5	8,233,933.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>14,471,157.8</b>	<b>22,705,091.5</b>	<b>8,233,933.7</b>

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл 11,561.4 мянган төгрөг болж, 387,799.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хэрэгжиж байгаа төслийн зарцуулалттай холбоотой байна. Төрийн сан дахь урсгал болон нэмэлт санхүүжилтийн дансны эцсийн үлдэгдлүүдийг улсын төсвийн орлогын дансанд татан төвлөрүүлжээ.

Авлага дансны үлдэгдэл 171,307.8 мянган төгрөг болж, 159,351.2 мянган төгрөгөөр өссөн нь оны эхний 11,956.6 мянган төгрөгийн үлдэгдлийг барагдуулж, нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдсэн 171,307.8 мянган төгрөгийг Сангийн яамтай тооцоо нийлж, авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 21,201.3 мянган төгрөг болж, 127,269.9 мянган төгрөгөөр буурсан нь 509,830.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, өмнөх аудитын зөвлөмжийн дагуу ТӨБЗГ-ын 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А1/76 тоот зөвшөөрөл олгох бичгээр 74,922.1 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэснээс голлон шалтгаалсан байна. Мөн тайлант онд 411,914.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 45,568.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 22,501,020.9 мянган төгрөг болж, 8,589,652.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,052,905.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор 7,770,717.1 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, ТӨБЗГ-ын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 220 мөн 12 дугаар сарын 24-ний өдрийн 815 дугаар тогтоолоор ашиглах хугацааг сунгаж, үнэ шинэчлэн тогтоосон хөрөнгө 1,866,913.3 мянган төгрөг, бараа материалаас үндсэн хөрөнгөнд шилжүүлэн бүртгэсэн 74,922.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс голлон нөлөөлсөн байна. Мөн ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 816 мөн 12 дугаар сарын 26-ний өдрийн 896 дугаар тогтоолоор 262,013.8 мянган төгрөгийн хөрөнгийг актлаж, үнэ шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор 2,330,391.6 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасч, ТӨБЗГ-ын 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 459 дүгээр тогтоолоор Хот байгуулалт, хотын стандартын газарт 175,130.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн өгч, тайлант хугацаанд тооцсон 2,029,964.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Биет бус хөрөнгөд нийт 17,240.0 мянган төгрөгийн 2 систем, 633,829.3 мянган төгрөгийн 3 программ хангамж бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 22,705,091.5 мянган төгрөг болж, 8,233,933.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 12,100,952.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 579,277.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 68,062.5 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 7,850.0 мянган төгрөгөөр, ээлжийн амралтаараа нутаг явах унаа байр ашиглалттай холбоотой зардлыг 47,464.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж бараа материалын зардлыг 34,212.2 мянган төгрөг, нормативт зардлыг 5,817.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 2,057,596.5 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 71,763.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 1,224,037.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 157,447.3 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлыг 6,450.0 мянган төгрөг, нийт 4,177,412.5 мянган төгрөгөөр бууруулж 7,923,539.5 мянган төгрөг баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгээгүй ба төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 7,923.539.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, 117,280.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 7,923,539.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,754,175.5 мянган төгрөг төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 125,775.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 45,072.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 95,893.6 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулалын зардлыг 10,282.3 мянган төгрөг, төрийн зарим чийг үүргийг хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх зардлыг 10,023.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас голлон нөлөөлсөн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/*

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>71805</b>	<b>Шинжлэх ухаан</b>	<b>7,923,539.5</b>	<b>7,754,175.5</b>	<b>169,364.0</b>	<b>97.9</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	7,132,418.8	6,992,802.1	139,616.7	98.0
80219	Харуул, хамгаалалтын зардал	344,174.0	337,169.7	7,004.3	98.0
80220	Холбооны суваг ашигласны хөлс	279,356.0	276,919.4	2,436.6	99.1
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх	82,493.3	72,470.2	10,023.1	87.8
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	85,096.4	74,814.1	10,282.3	87.9

Тайлант онд тус хүрээлэнгийн батлагдсан бүтэц, орон тоог 9 хувиар бууруулж цомхотгоогүй бөгөөд Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан орон тоо 200, гүйцэтгэлээр 181 орон тоотойгоор ажилласан байна.

Хүрээлэнгийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар хоолны зардлыг ажлын нэг өдөрт 17.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 0.5 мянган төгрөгөөр тогтоосон байсныг захирлын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн дугаар А/96 дугаар тушаалаар хоолны зардлыг ажлын нэг өдөрт 33.0 мянган төгрөг, унааны зардлыг 2.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

БНСУ-ын Геологийн Холбооноос зохион байгуулж буй "2025 Joint Fall Meeting of Korean Geological Societies and the 80 General Assembly of the Geological Society of Korea" сэдэвт хуралд оролцох гадаад томилолтын зардалд 12,942.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Шинжлэх Ухааны академи, "Тогтвортой хөгжлийн төлөө сэтгүүлчдийн клуб"-тэй 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр зурсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд шинжлэх ухааны 5-7 минутын хялбаршуулсан нэвтрүүлэг бүтээж, түгээх гэрээг 2025 оны 05 дугаар сарын 09-нд "Тогтвортой хөгжил түншлэл Амгалан дэлхий ТББ"-тай байгуулж, 2,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Шинжлэх ухааны Академийн Их Сургуулийн сургалт, Худалдан авах ажиллагааны А-3 сертификатын сургалт, Газрын гүний дулааныг ашиглах урьдчилсан суурь болон эдийн засгийн тооцоо, судалгааг хийх, туршлага солилцох сургалт, Геотермалын техник технологитой танилцах, Булнайн хагарал, газар хөдлөлтийн асуудлаарх олон улсын хурал, ОХУ-ын Эрхүү хотод Дэлхий царцдасын (ИЗК СО РАН) хүрээлэнд судалгааны хурал, Python-программ буюу Агаар, сансарын зургийн мэдээлэл боловсруулалтын сургалтуудад нийт 10,398.8 мянган төгрөгийн зарцуулалт гаргасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 978,752.5 мянган төгрөг, ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 49,566.7 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4,713.8 мянган төгрөг, нийт 1,033,032.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 852,837.8 мянган төгрөгийг зарцуулан, 180,195.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөөс 171,307.8 мянган төгрөгийг авлагаар тооцож, Төрийн сантай тооцоо нийлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хүрээлэн нь тайлант хугацаанд дараах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байна. Тус төсөл хөтөлбөрүүдээс 3 төсөл хөтөлбөр хэрэгжиж дууссан ба БНСУ-ын Гео судалгаа, эрдэс баялгийн хүрээлэнтэй хамтарсан Кигамын төсөл, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай хамтарсан гэрээт ажил, Геофизикийн магнетотеллурик судалгаа хөгжил, инновацийн төвтэй хамтарсан гэрээт ажил, Иргэний нисэхийн ерөнхий газрын гэрээт ажил, Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-тай хамтарсан ажил, Барилгын талбайд газар хөдлөлийн нарийвчилсан судалгаа хийх гэрээт ажил хэрэгжиж дуусаагүй, үргэлжилж байна. Геофизикийн магнетотеллурик судалгаа хөгжил, инновацийн төвтэй хамтарсан 30,000.0 мянган төгрөгийн төсөвтэй ажил санхүүжилтийн эрх нь нээгдээгүйгээс эхлээгүй байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт /мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгж их хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгж илтийн явц	Зарцуула х төсөв	Зарцуул сан
1	БНСУ-ын Гео судалгаа, эрдэс баялгийн хүрээлэнтэй хамтарсан Кигамын төсөл	2025-2026	Могодын газар хөдлөлийн динамик, кинематик загвар	50.26	134,263.7	67,478.2
2	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай хамтарсан гэрээт ажил	2025	УБ орчмын геотермаль потенциалын зураг, Геотермаль эсвэл Гидрогеологи гезерварын шинж чанарыг үзүүлсэн концепцийн загвар, УБ хотын Сэлбэ дэд төв, нийслэлийн дагуул хот Хүннү хот болон Төв аймаг Номтын ам орчмын талбайн нарийвчилсан 3D цахилгаан эсэргүүцлийн загвар болох гидрогеологи, геохимийн тайлан	87.97	300,000.0	263,740.4
3	Геофизикийн магнетотеллурик судалгаа хөгжил, инновацийн төвтэй хамтарсан	2025-2026	Геофизикийн магнетотеллурикийн хэмжилт, боловсруулалт, загварчлал	-	30,000.0	-
4	Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-тай хамтарсан	2025	Сорнзон хазайлтын өнцгийн утга тооцоолох программ хангамж шаардлаг	83.01	102,900.0	85,421.3

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			бүрэн хангасан программ хангамж, электрон файл			
5	Иргэний нисэхийн ерөнхий газар	2025-2026	Нарны мэдээллийн сан	30.00	1,920.0	576.0
6	Газар хөдлөлтийн сейсмшил судалгаа хийх гэрээт	2025	Сейсмшил судалгаа	67.27	7,168.6	4,822.2
7	Барилгын талбайд газар хөдлөлийн нарийвчилсан судалгаа хийх гэрээт ажил	2025-2026	Барилгын талбайн сейсмик судалгаа	86.01	138,936.0	119,496.0
8	Газар хөдлөлтийн аюулгүйн үнэлгээ хийх гэрээт ажил	2025	Геологийн маршрутын судалгаа, сейсмик хайгуулын судалгаа, талбайн нөлөөллийн судалгаа, газар хөдлөлийн аюулгүйн үнэлгээний тооцоолол	99.42	146,846.0	145,996.4
9	Тодруулга судалгааны ажил	2025	Тодруулга судалгаа	90.00	2,000.0	1,800.0
10	Франц улсын ENVIROARTH компанитай байгуулсан гэрээт ажил	2025	GNSS станц	100.00	6,774.2	6,774.2
11	Франц улсын ARIANEGROUP компанитай байгуулсан гэрээт ажил	2025	Од эрхэс ажиглах Дуран	99.98	19,584.7	19,580.0

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд багаж, техник хэрэгслийн зардалд 189,400.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, үүнээс 98,000.0 мянган төгрөгийн багаж, техник хэрэгсэл худалдан авахаар 2 цахим тендер зарлаж, 1 тендер амжилттай, 1 тендерийг 4 удаа зарлагдсан ч оролцогч байхгүй тул амжилтгүй болж, худалдан авах ажиллагааны батлагдсан төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан шууд худалдан авалтыг хийсэн байна.

Тус хүрээлэнгийн урсгал засварын зардалд 219,600.0 мянган төгрөг батлагдснаас 140,000.0 мянган төгрөгийн 2 засварын ажлын цахим тендерийг зарлаж, конторын засварын ажил 49,900.0 мянган төгрөг, Астропарк барилгын дээврийн бөмбөгөр хэсгийг шилэн фасадаар бүрэх ажил 89,572.5 мянган төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

Мөн орон нутаг дахь салбарууд, газар хөдлөлтийг бүртгэх хээрийн станцын засвар үйлчилгээ, соронзон байрны дээврийн засвар, төвийн байрны ус зайлуулах систем болон дулааны шугам засварын ажил зэрэг бусад урсгал засварыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн тус хүрээлэнгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 25-наас 2026 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Анализ старт аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг захирал Н.Энхтуяа, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхжин, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 12,370,048.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 123,700.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хязгаарласан заалтуудтай холбоотой зөрчил илрээгүй. Тухайлбал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан арга хэмжээ нь байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай шууд холбоотой бол хэмнэлтийн горимд хамааруулж болно гэж заасныг үндэслэн үндсэн чиг үүргийн хүрээнд оролцсон эрдэм шинжилгээний хурал, семинар, сургалттай холбоотой тайлант оны зарцуулалтыг зөрчилд тооцоогүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 14 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд төсвийн шууд захирагч нь байршуулбал зохих 192 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь ил тод, бүрэн байршуулж ажилласан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулалтыг харьцуулалтын аргаар тендер зарлаж, Монхорус Интернэшнл ХХК-тай Батарей сэлбэг хэрэгсэл нийлүүлэх 26,655.2 мянган төгрөг, Бий энд Ватст ХХК-тай конторын засварын ажлын 49,900.0 мянган төгрөг, Ононбридж ХХК-тай Астропаркийн барилгын дээврийн бөмбөгөр хэсгийг шилэн фасадаар бүрэх 89,572.5 мянган төгрөг, нийт 166,127.7 мянган төгрөгийн ажилд гэрээ байгуулж, гүйцэтгэлийг хангуулж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны тухай хууль болон ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж үндсэн хөрөнгө, бараа материал, орлого, зардал, өглөг дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулан нийт 874,473.5 мянган төгрөгийн 9 алдааг залруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 46,750.0.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 4,062.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актын нийт хэрэгжилт 100.0 хувьтай байна.

*Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт* /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4,062.0	1	4,062.0	100.0
Зөвлөмж	3	46,750.0	3	46,750.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>50,812.0</b>	<b>4</b>	<b>50,812.0</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

- Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны [finperform.mof.gov.mn](http://finperform.mof.gov.mn) сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
- Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 74,922.1 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан.

Залруулсан алдаа: УСНББОУС 3.46-д "... Тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг", УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шудрага илэрхийлэхийг шаарддаг. Шаардлагатай тохиолдолд бусад нэмэлт тодруулгын хамтаар УСНББОУС-ыг даган мөрдөх нь үнэн зөв толилуулгад хүргэх байдлаар санхүүгийн тайланд тусгах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Ангилал" батламж мэдэгдлийг хангаагүй дараах ажил гүйлгээг аудитын явцад залруулав. Үүнд:

- Бараа материалыг Үндсэн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэхдээ "Үнэ төлбөргүй орлого" дансанд бүртгэж, дансны бичилт буруу бүртгэсэн байна.

Аудитаар нийт 2,014.6 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 зөвлөмж өглөө.

### 5.1 Зөвлөмж

#### 1. НБББББ, Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг"-ийг баримтлан номыг бүртгэлд тусгахдаа буруу ангилан багцлан бүртгэсэн байна. Мөн 2024 оны 9 дүгээр сараас Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад шилжсэн боловч НБББББ-д өөрчлөлт оруулан боловсруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг" мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Стандарт, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан НБББББ-ийг төсвөөс зардал гаргахгүйгээр өөрчлөлт оруулан боловсруулах, багцлан бүртгэсэн номыг нэгжийн үнээр салгаж бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалыг Үндсэн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэхдээ "Үнэ төлбөргүй орлого" дансанд бүртгэсэн.	1	74,922.1			1	74,922.1	1	74,922.1				
Дүн	1	74,922.1			1	74,922.1	1	74,922.1				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг"-ийг баримтлан номыг бүртгэлд тусгахдаа буруу ангилан багцлан	1	2,014.6					1	2,014.6				

бүртгэсэн байна. Мөн 2024 оны 9 дүгээр сараас Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад шилжсэн боловч НБББББ-д өөрчлөлт оруулан боловсруулаагүй байна.												
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,014.6</b>					<b>1</b>	<b>2,014.6</b>				